



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№112 /326/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.06.21

Цаг үе, үйл явдал

ЭНЭТХЭГ-НОМХОН ДАЛАЙ ДАХЬ АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫН ОРЛОГЧ ДАРГА ХОШУУЧ ГЕНЕРАЛ КРИС СМИТЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Энэтхэг-Номхон далай дахь Америкийн Нэгдсэн Улсын Хуурай замын цэргийн командлалын орлогч дарга хошууч генерал Крис Смитыг өнөөдөр хүлээн авч уулзлаа.

Уулзалтад Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Энэтхэг-Номхон далай дахь Америкийн Нэгдсэн Улсын Хуурай

замын цэргийн командлалын орлогч дарга хошууч генерал Крис Смит, БХЯ-ны СБТГ-ын дарга хурандаа С.Гандирваа, ГХАГ-ын дарга хурандаа Б.Бат-Эрдэнэ, ахлах мэргэжилтэн хурандаа С.Амарсайхан, Зэвсэгт хүчний Хуурай замын штабын дарга хурандаа Д.Дугарагчаа, АНУ-аас Монгол Улсад суугаа Батлан хамгаалахын атташе дэд хурандаа Ф.Лью болон бусад албаны хүмүүс байлцлаа.



Уулзалтаар хоёр орны Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа нь дээд, дунд түвшний харилцан айлчлал хийх, Батлан хамгаалах яамд хоорондын болон төрлийн цэргийн командлал хоорондын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах, Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг сахиулах ажиллагаанд оролцох чадварыг нэмэгдүүлэх, цэргийн мэргэжлийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх, хамтарсан сургалт, дадлагаар харилцан

туршлага солилцох зэрэг олон хэлбэрээр амжилттай хамтран ажиллаж, үр дүнд хүрч байгаад Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Энэтхэг-Номхон далай дахь Америкийн Нэгдсэн Улсын Хуурай замын цэргийн командлалын орлогч дарга хошууч генерал Крис Смит нар санал нэгдэж, сэтгэл хангалуун байгаагаа харилцан илэрхийлээд цаашид улам бэхжүүлэн хөгжүүлэх талаар санал солилцлоо.

ЗАВХАН АЙМГИЙН “ДӨЛ”-ИЙН ШИЛДГҮҮД ТОДОРЛОО



Зэвсэгт хүчний 325 дугаар анги боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулагдаж буй Цэрэг-Спортын “Дөл” тэмцээн Завхан аймаг болон сумуудын хэмжээнд энэ сарын 16,17-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа.

Уг тэмцээнд нийт 9 сургуулийн ахлах ангийн 135 сурагчид хоёр өдрийн турш жагсаалын үзүүлэх тоглолт, гардан тулаан, галын бэлтгэлийн норматив, бкм-н маршийн замыг туулах гэсэн үе шаттайгаар авхаалж самбаа, хурд хүчээ сорин өрсөлдлөө. Цэрэг-Спортын “Дөл” тэмцээний нээлтэд аймгийн засаг дарга Д.Түвшинжаргал, ЗДТГ-ын хурлын дарга Г.Мягмарсүрэн, ЗДТГ-ын Цэргийн штабын дарга Г.Үнэнбаяр болон Ерөнхий боловсролын сургуулиудын багш нар болон бусад албаны хүмүүс хүрэлцэн ирж

оролцлоо. Хүүхэд залуучуудад цэрэг эх оронч үзэл төлөвшүүлэх, бие бялдрын болон сэтгэл зүйн хүмүүжил олгох зорилгоор зохион байгуулж буй уг тэмцээнд Улиастай сумын Д.Мөнхбаяр багштай IV сургууль “Тэргүүн байрт”, Тосонцэнгэл сумын Х.Алтангэрэл багштай I сургууль “Дэд” байрт, Улиастай сумын Б.Идэрбат багштай II сургууль “Гутгаар” байрт тус тус шалгарч шилжин явах цом болон өргөмжлөл, алт, мөнгө, хүрэл медалиудаар тус тус шагнагдлаа.

Тус тэмцээнийг Завхан аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Зэвсэгт хүчний 325 дугаар анги, Онцгой байдлын газар хамтарч бэлтгэл ажлыг хангаж, шаардлагатай техник хэрэгсэл, эд материал болон хариуцлагатай шүүгчдийг томилон хамтран ажиллаа.



АВТОМАШИНУУДЫН УЛСЫН ҮЗЛЭГ ТООЛЛОГОДОО ИДЭВХТЭЙ ХАМРАГДАХЫГ АНХААРУУЛЖ БАЙНА



Зэвсэгт хүчний тээврийн хяналтын алба

ЗЭХЖШ-ын даргын тушаалаар Зэвсэгт хүчний нэгтгэл, анги байгууллагуудын тээврийн бүлгийн автомашинуудын улсын үзлэг тооллого явагдаж эхлээд байна. Үзлэг тооллогыг Зэвсэгт хүчний тээврийн хяналтын алба хойд, зүүн, урд, баруун, төв гэсэн таван чиглэлээр бүсчлэн явуулдаг ба эхний ээлжид хойд бүсийн үзлэг тооллого явагдаж дуусаад байна.

Дараагийн дугаарт зүүн болон төвийн бүсийн нэгтгэл, анги, байгууллагуудын үзлэг тооллого эдгээр өдрүүдэд явагдаж байгаа тул анги байгууллагууд тээврийн хэрэгслийнхээ өнгө үзэмж, техникийн бүрэн бүтэн байдлаа хангаж, улсын үзлэг тооллогод бэлдэхийг Зэвсэгт хүчний тээврийн хяналтын албанаас зөвлөж байна.

Ахлах дэслэгч Д.ГАНХУЯГ



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

Өдөр	Шөнө
☀️ 24	🌙 10

ӨМНӨД СУДАН

Өдөр	Шөнө
☀️ 37	🌙 25

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,123.00	3,126.0
EUR 🇪🇺	3,290.0	3,305.0
CNY 🇨🇳	465.00	468.00
RUB 🇷🇺	50.10	50.50
JPY 🇯🇵	23.40	23.70
KRW 🇰🇷	2.46	2.48

ЗУРХАЙ



2022.06.21 /МЯГМАР ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 23

ЗУНЫ ИЛҮҮ ТЭРГҮҮН САРЫН ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:
Эд эдлэл идээ ундаа олдоно
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
04.53-20.55
Барилдлага:
Үхэх
Шүтэн барилдлага:
Төрөхүй
Суудал: Шороо

Энэ өдөр үхэр жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, хараал, жатхыг буцаах, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, гэр бүрэхэд сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх зэрэг үйлд муу.

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, эдлэл, идээ, ундаа олно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 544,853,490

Эдгэрсэн

Нийт: 520,125,490

Нас барсан

Нийт: 6,341,827

Цахим шууданд

ОФИЦЕР, АХЛАГЧ НАРТ ЁС ЗҮЙН ДҮРМЭЭР СУРГАЛТ ЯВУУЛЛАА



Алба хаагчдынхаа хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулж байна. Энэ удаа ангийн Ажиллагааны удирдлагын тасгийн дарга хошууч Д.Алтаншагай "Захирах, захирагдах ёс", цэргийн алба, хөдөлмөрийн аюулгүй байдлын офицер хошууч Ц.Мөнхбаяр "Зэвсэгт

хүчний офицер, ахлагчийн ёс зүйн дүрэм", хуулийн офицер ахмад В.Цэрэнпил "Ашиг сонирхлын зөрчил" сэдвүүдээр сургалт явуулсан юм. Энэ нь Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагчийн албан даалгаврын хэрэгжилтийг хангах, Цэргийн нийтлэг дүрмүүдийг чанд сахин

биелүүлж, захирах, захирагдах ёс, цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөх зэрэг хууль тогтоомжоор хүлээсэн нийтлэг үүргийг ойлгуулах, зөрчүүлэхгүй байхад оршиж байгаа юм.

Хошууч О.ОТГОНЦЭЦЭГ

АХМАД, ДУНД, ЗАЛУУ ҮЕИЙН УУЛЗАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАВ



ахмад настуудынхаа хийж бүтээсэн ажил үйлсээр бахархсан хүндлэл дүүрэн өдөр болж өнгөрсөн юм.

Мөн Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчин байгуулагдсаны 101 жилийн ойд зориулан Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас сурагчдын авьяас чадварыг нээн хөгжүүлэх, хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, Монгол цэрэг олон Улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойн хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд "Монгол цэрэг-Дэлхийн цэрэг" сэдвээр зохион бичлэгийн уралдааныг амжилттай зохион байгуулсан. Тус уралдаанд дүүргийн Ерөнхий боловсролын 18 сургуулийн ахлах ангийн сурагчдын нийт 500 гаруй бүтээл ирснээс уралдааны шилдэг бүтээлүүдийг сонгон шалгаруулахад тэргүүн байрт Сэтгэмж Цогцолбор сургуулийн 10 "А" ангийн сурагч Н.Итгэл, дэд байрт 38 дугаар сургуулийн 10 "З" ангийн сурагч М.Хануй, гутгаар байрт 51 дүгээр сургуулийн 10 "А" ангийн сурагч М.Энхболд нарыг тус тус шалгаруулав. Энэ үеэр шилдэг эсээ бичлэгийг уншиж, танилцуулан "батламж", мөнгөн шагналыг дүүргийн удирдлагууд гардуулан өгсөн юм.

Баянгол дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб Монгол Улсад "Генерал" цол бий болсны 78 жилийн ойг тохиолдуулан дүүрэгт оршин суудаг бэлтгэл генералуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгууллаа. Хүндэтгэлийн арга Баянгол дүүргийн Засаг даргын орлогч Г.Нарангэрэл, засаг даргын зөвлөх Ж.Баатар, Тамгын газрын дарга Б.Нарангэрэл, төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Мөнгөнхуяг Цэргийн штабын дарга, хурандаа Л.Цэрэнбаяр нараас гадна тус дүүрэгт оршин суудаг дэслэгч генерал Ц.Дашзэвэг, хошууч генерал Ч.Цэрэндагва, Л.Пүрэвдорж, Б.Эрдэнэбат, Ж.Ишдорж, бригадын генерал Ч.Сосорбарам,

Б.Даваадорж нарын хүндэт зочид оролцлоо. Тус арга хэмжээний хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохиогдсон дүүргийн Засаг даргын нэрэмжит Цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнд авхаалж самбаа, хурд хүчээ сорин өрсөлдөж эхний 6 байрт шалгарсан баг тамирчид, дасгалжуулагч багш нараас гадна 2021 оны 2 дугаар ээлжээр цэргийн жинхэнэ албанд татагдан Зэвсэгт хүчний 120, Хилийн цэргийн 0151 дүгээр ангиудад хугацаат цэргийн алба хааж байгаа дайчид болон тус ангиудын бие бүрэлдэхүүн цахимаар оролцсон юм. Ахмад, дунд, залуу үеийн төлөөлөл оролцсон эл арга хэмжээ нь хүүхэд залууст цэрэг эх оронч үзэл, хүмүүжил олгохоос гадна

АФГАНИСТАН УЛСАД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭСЭН АЛБА ХААГЧИДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



Зэвсэгт хүчний 303 дугаар анги Афганистан улсад "Тогтвортой эрх чөлөө" ажиллагааны "Нисдэг тэрэгний техникийн засвар, үйлчилгээний сургалтын баг /НТТЗУСБ/"-т үүрэг гүйцэтгэсэн цэргийн алба хаагч болон цэргийн бэлтгэл үүрэгтнүүдэд хүндэтгэл үзүүлэх ёслолын ажиллагааг энэ сарын 18-ны өдөр Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн байрлалд зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээнд

Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч хошууч генерал О.Энхбаяр, Монгол Улсын гавьяат нисгэгч бэлтгэл хурандаа Б.Дашаахүү, агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсийн дарга хурандаа Н.Очирбат, Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн удирдлага, бие бүрэлдэхүүн болон бусад хүндэт зочид оролцлоо. Агаарын цэргийн командлагч хошууч генерал О.Энхбаяр арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ ОХУ-ын

нисдэг тэргийг өөрийн мэт эзэмшиж, ашиглан цаашлаад Афганистан улсын нисэх хүчний бие бүрэлдэхүүнд сургах хэмжээний нисэхийн боловсорсон нисэхийн мэргэжилтнүүдээрээ үргэлж бахархаж явдгаа онцлов. Арга хэмжээний хүрээнд "Нисдэг тэрэгний техникийн засвар, үйлчилгээний сургалтын баг"-т үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдын зүгээс удирдах бүрэлдэхүүнд дурсгалын зүйл гардууллаа.

Ахмад О.МАНДАХБАЯР

"БҮХ ЦЭРГИЙН ОВОО"-Г ТАХИВ



Зэвсэгт хүчний 331 дүгээр анги Өлгий цэргийн хүрээний "Бүх цэргийн овоо"-г тахив ёслолыг Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн аргын тооллын 6 дугаар сарын 15, билгийн тооллын 16, шарагчин гахай өдөр зохион байгууллаа. Тахилгын ёслолыг Баян-Өлгий аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Ц.Буянтогтох,

Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа С.Бат-Эрдэнэ нар удирдан, Раашгэнпэллин хийдийн тэргүүн лам Г.Батхүү хуралцан ирж, ном хурж, тахилгын ёсыг үйлдлээ. "Бүх цэргийн овоо"-г тахив ёслолын ажиллагаанд зориулж, ангийн бие бүрэлдэхүүний дунд Үндэсний бөхийн

барилдаан, шагайн харваа, урианхай сурын харвааны тэмцээнийг зохион байгуулсан бөгөөд үндэсний бөхийн барилдаанд дэд ахлагч Ч.Пэлжид түрүүлж, шагайн харвааны тэмцээнд Баян-Өлгий аймгийн гоц мэргэн энгийн Я.Амарсанаа, урианхай сурын харваанд энгийн Д.Дандар нар тус тус тэргүүллээ.

Ахлах дэслэгч Б.ГЭРЭЛТ-ОД

